СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

2022 оны 11 дүгээр сарын 14 Улаанбаатар хот

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу шалгуур үзүүлэлт, аргачлалаар үнэлгээг гүйцэтгэв.

Журамд заасны дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Төрийн Захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг уншиж танилцах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж, ярилцах, холбогдох мэдээллийг ашиглан хийсэн.

ХОЁР. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг ДИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 08 дугаар “Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолоор батлагдсан.

ДЗДҮАХ-ийг тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөө нь “Дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөө” байдаг. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 3/01 дугаар “Сүхбаатар дүүргийн 2021 оны хөгжлийн Жилийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор 6 бүлэг 253 арга хэмжээтэй батлагдсан.

Дүүргийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд ДЗДҮАХ-ийн 136 зорилтоос 132 зорилт тусгагдаж, жилийн эцсийн тайлан гарсан байна.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ “ХӨГЖИЛД ХӨТЛӨХ СҮХБААТАР ДҮҮРЭГ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

2022 оны 11 дүгээр сарын 14 Улаанбаатар хот

№	Агуулга		Бүгд	НЭГ. “Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	ХОЁР. Хүний хөгжлийн бодлого /эрүүл мэнд, боловсрол/	ГУРАВ. Эдийн засгийн бодлого /өсөлтийг өрх бүрд/	ДӨРӨВ. Засаглалын бодлого /нээлттэй хариуцлагатай дүүрэг/	ТАВ. Ногоон хөгжлийн бодлого /амьдрахад таатай дүүрэг/	ЗУРГАА. Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого
1	Нийт заалтын тоо		132	**3**	**55**	**6**	**42**	**19**	**7**
2	“Үр дүнтэй”	100%	104	3	44	5	29	18	5
3	“Тодорхой үр дүнд хүрсэн”	70-99%	25		9	1	13	1	1
4	“Эрчимжүүлэх шаардлагатай”	31-69%	3		2				1
5	“Үр дүнгүй”	0-30%							
Дундаж хувь			97.4%	**100.0%**	**94.9%**	**99.7%**	**95.8%**	**99.5%**	**94.7%**

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн “Эрчимжүүлэх шаардлагатай” 3 арга хэмжээг анхаарч, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ 3 АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Хүснэгт 3.

№	ДЗДҮАХ-ийн зорилт	Арга хэмжээ	Хувь	Хариуцах хэлтэс
1	2.3.5	“Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцыг эрчимжүүлж, ашиглалтад оруулна.	40%	НХХ БТСХ
2	2.5.8	Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана.	50%	ХХҮХ
3	6.1.1	“Зуслангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	68%	ГЗБА

АНХААРАХ: ДЗДҮАХ-ийн 4.5.2 арга хэмжээнд явын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **Дүүргийн Цагдаагийн газраас өмнөх оны биелэлтийг ирүүлсэн байсан. Жилийн эцсийн биелэлтийг дахин авахад өмнөх алдаагаа засалгүй дахин өмнөх оны биелэлтээ ирүүлсэн.**

Өмнөх жилийн биелэлт ирүүлсэн: “Олон нийтийн цагдааг хороодод ажиллуулснаар хороодод **бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 5,5-15,7 хувиар буурсан бөгөөд 2021 оны эхний 10 сарын байдлаар 1862 гэмт хэрэг бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үеэс 187 гэмт хэргээр буюу 9.1 хувиар буурсан**.”

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дараах асуудлыг нийт хэлтэс, албад анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- 1 арга хэмжээний хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаах /УБХ, ЦГ/
- Тоо болон чанарын үзүүлэлтийг нарийвчлан тусгах, ерөнхий өгүүлбэрээр биелэлт гаргахгүй болохыг анхаарах
- /Igovernment.mn/ сайтад байгаа тайлан биелэлт гаргахад тавигдах шаардлагуудыг хангах
- Хэлтэс, нэгжүүд тайлангаа гаргахдаа хүрсэн түвшин бүрхэг, хэт ерөнхий, эсхүл төлөвлөсөн арга хэмжээтэй биелэлт нь тохирохгүй байх нь түгээмэл байна.

- Албан хэрэг хөтлөлтийн стандарт, үг үсэг, утга найруулгын алдааг хянах, засаж сайжруулахад анхаарч ажиллана уу.

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ЭНХБОЛД

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.БЯМБАСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ИРГЭНИЙ ОРОЛЦОО
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.НЯМДОРЖ